



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 9 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар
хот

Гадаадад суралцуулах
тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Норов овогтой Амартүвшинг Англи улсын Абердиний их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 1.5 жилийн хугацаагаар, Цэдэв овогтой Цолмонг Англи улсын Эксэтэрийн их сургуулийн магистрантурт олон улсын бизнесийн эрх зүйн чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Санжаадорж овогтой Мөнжжаргалыг Швейцарь улсын Женевийн их сургуулийн магистрантурт байгаль орчны эрх зүйн чиглэлээр 1 жилийн хугацаагаар тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан (Б.Ганбат), энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар (М.Баасанжав)-т тус тус даалгасугай.

САЙД

А.Цанжид

А.ЦАНЖИД

Дуудвар

үрэл: с/м

Б. Энхтөгс
2001.9.10.